

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР ¹ 05 (ТОЙМ)

Хуралдаан 2010 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 14.30 цагт эхэлж, 15.30 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 1 цаг 00 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд нэр дэвшүүлж, дүгнэлт гаргах тухай	ТАЗ-ийн 2010-02-11-ний өдрийн 23 дугаар тогтоолоор Ч.Дашням, М.Алтангэрэл нарыг ҮХЦ-ийн ТГ-ын даргын албан тушаалд томилогдох ажилтны нөөцөд бүртгэж, Ч.Дашнямыг уг албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, ҮХЦ-ийн даргад санал болгосон.
2	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас төрийн захиргааны зарим албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах талаар ирүүлсэн саналын тухай	Хоёр албан хаагчид тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар, 10 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар шийдвэрлэж, саналаа МУ-ын ЗГ-ын ХЭГ-т уламжилсан.
3	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	ТАЗ-ийн 2010-02-12-ны өдрийн 26 дугаар тогтоолоор БТСГ-ын дэргэдэх ТАЗСЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, мөн өдрийн 25 дугаар тогтоолоор тус ТАЗСЗ-ийн даргаар Ч.Наранбаатар, нарийн бичгийн даргаар Г.Оюунчимэг нарыг тус тус томилгов.
4	Баян-Өлгий аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	ТАЗ-ийн 2010-02-12-ны өдрийн 27 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймгийн ТАЗСЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, мөн өдрийн 24 дүгээр тогтоолоор тус ТАЗСЗ-ийн даргаар Б.Зархум, нарийн бичгийн даргаар Т.Танай нарыг тус тус томилгов.